



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/507

Чингис хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.7, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/131 дугаар тушаалын 7.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт орших Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Өндөрхаан” нисэх буудлын аэродромын тусгай бүс болон ойртолтын бүсийн эргэлтийн цэгийн солбицлыг нэгдүгээр хавсралтаар, хамгаалалтын бүсийн зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

2. Аэродромын ойртолтын болон тусгай бүсэд барилга байгууламж барих тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар, Өндөрхаан нисэх буудалтай зөвшилцөж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-д даалгасугай.

3. Аэродромын орчмын аюулгүйн бүсэд байгаа иргэн, аж ахуй нэгжийн явуулж буй үйл ажиллагаа, шинээр газар олголт зэрэг нь нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж байгаад хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга /Б.Энх-Эрдэнэ/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/, Өндөрхаан нисэх буудлын дарга /Д.Цэрэндондов/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/, Нисэх буудлын дарга /Д.Цэрэндондов/ нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хэнтий аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/475 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010871

Аймгийн Засаг даргын 2020 оны  
11 дугаар сарын 03 өдрийн А/504  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт


Аэродромын тусгай бүс, ойртолтын бүсийн  
эргэлтийн цэгийн солбицол

1. Аэродромын тусгай бүс

№	Цэгийн солбицол ITRF 97/19-бүс	
	X	Y
1	5246171.43	473079.17
2	5244804.45	474540.19
3	5237061.01	467295.11
4	5238427.99	465834.10
5	5242299.71	469456.63
6	5240932.73	470917.65

2. Аэродромын ойртолтын бүс

№	Цэгийн солбицол ITRF 97/19 - бүс	
	X	Y
7	5255811.46	478061.01
8	5250415.63	483828.00
9	5242484.91	471088.94
10	5242573.73	470994.01
11	5232816.82	456546.28
12	5240747.53	469285.35
13	5240658.72	469380.27
14	5227420.98	462313.28



Тайлбар:



Тусгай бүс



Агаарын хөлгийн ойртолтын бүс



"А" БҮС



"Б" БҮС

Зураг 7.5-1. Аэродром орчмын аюулгүйн бүс

Хуудас 205  
2020 А/Б